



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ихтамир сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2025/7/-НА-СТА-ТТЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Архангай аймаг 2025 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: <a href="mailto:Baigalmaat@audit.gov.mn">Baigalmaat@audit.gov.mn</a> Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: <a href="mailto:Nerguibaatar@audit.gov.mn">Nerguibaatar@audit.gov.mn</a> Аудитор <b>А.Пүрэвцэцэг</b> Цахим хаяг: <a href="mailto:Purevtsetsega@audit.gov.mn">Purevtsetsega@audit.gov.mn</a></p>
--------------------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>3</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....</b>	<b>5</b>
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>8</b>
<b>3.1 Албан шаардлага.....</b>	<b>8</b>
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....</b>	<b>9</b>

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол улсын засгийн газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХГБХХГ	Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.03.25 № 166  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ИХТАМИР СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Г.ОРОЛМУУ ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Ихтамир сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Хоршоо хөгжүүлэх сангийн 30 зээлдэгчтэй холбоотой 80,154.5 мянган төгрөгийн чанаргүй хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй;
2. Сумын 2024 оны төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 311,093.1 мянган төгрөгөөр давж биелсэн боловч 7 нэр төрлийн орлогыг төлөвлөснөөс 11,345.9 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн;

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1, 44 дүгээр зүйлийн 44.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.1, 13 дугаар зүйлийн 13.1, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.23.1, 3.9.7, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох,сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11, 10 дугаар зүйлийн 10.1, 11 зүйлийн 11.3 дахь заалттай нийцээгүй бөгөөд

санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, соёл урлаг, ерөнхий боловсрол, эрүүл мэндийн бодлого удирдлага, сургуулийн өмнөх боловсрол гэсэн 9 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 3,193,480.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 2,620,287.4 мянган төгрөгийг зарцуулж, төлөвлөснөөс 573,193.3 мянган төгрөг зарцуулагдаагүй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Сумын засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 15 үндсэн зорилтын хүрээнд 131 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 82.7 хувийн гүйцэтгэлтэй үнэлсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	974,827.20	1,476,326.10
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	534,491.50	1,083,140.20
33	АВЛАГА	408,154.70	314,098.00
34	УРЬДЧИЛГАА	0	10,400.00
35	БАРАА МАТЕРИАЛ	12,681.00	25,148.00
36	НӨӨЦИЙН БАРАА	19,500.00	43,540.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,075,441.80	4,360,195.30
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,075,441.80	4,360,195.30
39200	Биет хөрөнгө	4,030,562.00	4,315,600.50
39300	Биет бус хөрөнгө	44,879.80	44,594.80
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,050,269.00	5,836,521.40
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,050,269.00	5,836,521.40
51	Засгийн газрын хувь оролцоо	5,050,269.00	5,836,521.40
51100	Засгийн газрын оруулсан капитал	627,640.10	627,640.10
51200	Хуримтлагдсан үр дүн	3,755,858.80	4,542,111.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	666,770.10	666,770.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,050,269.00	5,836,521.40

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,079,404.10	3,505,956.20
11	ТАТВАРЫН ОРЛОГО	595,823.30	1,021,715.80
110	Орлогын албан татвар	293,249.10	758,414.80
1100	Хувь хүний орлогын албан татвар	292,831.80	758,236.30
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	417.40	178.50
113	Хөрөнгийн албан татвар	112,140.80	91,025.10
118	Бусад татвар, төлбөр, хураамж	190,433.40	172,276.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	418,734.40	677,505.50
120	Нийтлэг татварын бус орлого	418,734.40	677,505.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,064,846.40	1,806,734.80
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,665,621.60	2,205,160.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,665,621.60	2,205,160.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,647,172.70	2,044,732.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	563,405.50	893,533.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,010.50	113,158.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,463.90	418,409.30
2104	Хангамж, бараа материалын зардал	119,479.30	69,684.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,129.30	128,299.40
2107	Томилолт, зочны зардал	6,778.00	15,924.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	652,098.90	105,441.50

**Архангай аймгийн Ихтамир сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	188,807.30	300,281.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,448.80	160,427.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	413,782.60	1,300,796.20
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	318,753.80	514,543.80
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	95,028.80	786,252.40

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,993,137.60	3,242,814.40
11	ТАТВАРЫН ОРЛОГО	595,823.30	1,021,715.80
110	Орлогын албан татвар	293,249.10	758,414.80
1100	Хувь хүний орлогын албан татвар	292,831.80	758,236.30
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	417.40	178.50
113	Хөрөнгийн албан татвар	112,140.80	91,025.10
118	Бусад татвар, төлбөр, хураамж	190,433.40	172,276.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	30,343.40	23,365.60
1181	Газрын төлбөр	90,247.00	4,866.20
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	69,843.00	144,044.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	332,467.90	414,363.70
120	Нийтлэг татварын бус орлого	332,467.90	414,363.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,064,846.40	1,806,734.80
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,519,172.70	2,089,827.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,519,172.70	2,089,827.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,500,723.80	1,919,000.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	563,405.50	893,533.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,010.50	113,158.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,463.90	418,409.30
2104	Хангамж, бараа материалын зардал	67,395.10	70,104.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,414.30	139,672.40
2107	Томилолт, зочны зардал	6,778.00	15,924.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	652,098.90	109,381.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	94,157.60	158,816.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,448.80	170,827.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	473,965.00	1,152,986.80
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	363,979.80	584,338.20
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	363,979.80	584,338.20
2200	Дотоод эх үүсвэрээр	363,979.80	584,338.20
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(363,979.80)	(584,338.20)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(120,000.00)	(20,000.00)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	120,000.00	20,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(10,014.90)	548,648.60
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	544,506.40	534,491.50
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	534,491.50	1,083,140.20

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

**Архангай аймгийн Ихтамир сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,955,240.20	4,955,240.20
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,955,240.20	4,955,240.20
9	Тайлант үеийн үр дүн	95,028.80	95,028.80
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,050,269.00	5,050,269.00
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,050,269.00	5,050,269.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,050,269.00	5,050,269.00
19	Тайлант үеийн үр дүн	786,252.40	786,252.40
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,836,521.40	5,836,521.40

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	3,193,480.70	2,620,287.43	573,193.27	82.05
21	Урсгал зардал	2,302,649.50	2,088,697.61	213,951.89	90.71
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	2,119,201.40	1,917,870.09	201,331.31	90.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	929,391.40	893,533.63	35,857.77	96.14
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,812.60	113,158.47	2,654.13	97.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	495,808.60	418,409.32	77,399.28	84.39
2104	Хангамж, бараа материалын зардал	71,743.30	70,104.02	1,639.28	97.72
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	214,812.70	200,645.65	14,167.05	93.40
2107	Томилолт, зочны зардал	17,152.00	15,924.50	1,227.50	92.84
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	133,486.60	68,563.46	64,923.14	51.36
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	140,994.20	137,531.05	3,463.15	97.54
213	Урсгал шилжүүлэг	183,448.10	170,827.52	12,620.58	93.12
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	20,250.00	10,400.00	9,850.00	51.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	63,198.10	160,427.52	2,770.58	98.30
22	Хөрөнгийн зардал	721,831.20	511,589.82	210,241.38	70.87
23	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	169,000.00	20,000.00	149,000.00	11.83
III	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	3,193,480.70	2,665,307.56	528,173.14	83.46
32	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,486,669.20	2,471,778.96	14,890.24	99.40
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	706,811.50	193,528.60	513,282.90	27.38
61	Байгууллагын тоо	3.00	3.00	-	100.00
62	Ажиллагсадын тоо	32.00	32.00	-	100.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар залруулагдаагүй 91,500.4 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>1</sup> илэрч 80,154.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага 11,345.9 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар илэрсэн 91,500.4 мянган төгрөгийн зөрчлийг материаллаг гэж үнэлснээс гадна санхүүгийн тайланд нэгтгэгдсэн харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн 45,937.7 мянган төгрөгийн зөрчлийн нөлөөллийг үнэлж нийт **137,438.1** мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг зөрчил гэж үзлээ. Энэ нь аудитын төлөвлөлтийн үе шатанд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн **35,926.6** мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

#### 3.1 Албан шаардлага

Хоршоо хөгжүүлэх санд 30 зээлдэгчтэй холбоотой 80,154.5 мянган төгрөгийн чанаргүй хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 10 дугаар зүйлийн 10.1-т “Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина”, 11 зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:** Зөрчлийг таслан зогсоож, хоршоо хөгжүүлэх сангийн чанаргүй зээлийн авлагыг барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллах.

#### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

##### 3.2.1. Орлоготой холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Сумын төсвийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлээр 7 нэр төрлийн орлого нийт 11,345.9 мянган төгрөгөөр тасарсан, төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх талаар арага хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Сумын орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэх, төлөвлөсөн орлогыг бүрэн төвлөрүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллан, орлогын төлөвлөгөөний биелэлтийг сар, улирлаар хянаж, үр дүнг дүгнэж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

*Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр*

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Запуулсан		Запуулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ХХС	1	80,154.5	-	-	1	80,154.5						
Орлоготой холбоотой	1	11,345.9	-	-	-	-	1	11,345.9	-	-	-	-
НИЙТ ДҮН	2	91,500.4	-	-	1	80,154.5	1	11,345.9	-	-	-	-

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн данс	1	-	-	-	-	-	1	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
-	-	-	-	-	-	-	-	-	-

**5. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИД НЭГТГЭГДСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс:									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
ЗДТГ	4	34,060.6	1	4,925.5	2	3,060.0	1	26,075.1				
ИТХ	2	11,877.1	1	1,477.1	1	10,400.0					-	-
ЗД	1	11,345.9	-	-	-	-	1	11,345.9				
ХХС	1	80,154.5	-	-	1	80,154.5						
Шилэн данс	1											
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>137,438.1</b>	<b>2</b>	<b>6,402.6</b>	<b>4</b>	<b>93,614.5</b>	<b>2</b>	<b>37,421.0</b>				